



МОНГОЛ УЛС
ХӨВСГӨЛ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2023 оны 02 сарын 01 өдөр

Дугаар А/35

Мөрөн сум

Нэмэлт төсвийн данснаас төвлөрүүлсэн
хөрөнгийг буцаан олгох тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 66 дугаар зүйлийн 66.1, сангийн сайдын 2019 оны 03 дугаар сарын 27-ны өдрийн 74 дүгээр тушаалыг тус ус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:


1. Аймгийн төрийн санд 2022 оны жилийн эцэст нэмэлт төсвийн данснаас төвлөрүүлсэн Байгаль орчин, аялал жуулчлалын газрын 31,489,332 (гучин нэгэн сая дөрвөн зуун наян есөн мянга гурван зуун гучин хоёр) төгрөг, аймгийн Засаг даргын Тамгын газрын 4,128,500 (Дөрвөн сая нэг зуун хорин найман мянга таван зуун) төгрөгийг тухайн байгууллагуудад буцаан олгосугай.

2. Асрамжийн газрын 321.50 (гурван зуун хорин нэгэн төгрөг 50 мөнгө)-ийг орон нутгийн орлогод тооцсугай.

3. Байгууллагуудын нэмэлт төсвийн данснаас төвлөрүүлсэн 35,617,832 (гучин таван сая зургаан зуун арван долоон мянга найман зуун гучин хоёр) төгрөгийг буцаан олгож, 321,50 (гурван зуун хорин нэгэн төгрөг 50 мөнгө)-ийг аймгийн ерөнхий орлогын дансанд шилжүүлэхийг Санхүү, төрийн сангийн хэлтсийн дарга (Г.Базар), аймгийн Төсвийн ерөнхий нягтлан бодогчийн албан үүргийг түр орлон гүйцэтгэгчид тус тус зөвшөөрсүгэй.

4. Захирамжийн хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг аймгийн Засаг даргын орлогч (М.Хуягбаатар)-д үүрэг болгосугай.

ДАРГА



Ш.ИДЭРБАЯСГАЛАН